

ДАЯАРШЛЫН ҮЕИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ БА
СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАЛТ

М. Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор, профессор

Түлхүүр үг: шавь төвтэй сургалт, судалгааны их сургууль, дээд боловсролын глобалчлал, шинжлэх ухаан-сургалт-үйдвэрлэлийн цогцолбор

Монгол Улсад дээд боловсролын эх суурь тавигдсанаас хойшх 70 гаруй жилийн хугацаанд дээд боловсролын систем бүрэлдэн тогтож, улс орны бараг бүх салбарын мэргэжилтнүүдийг бэлгэх болсон. Дэлхийн хөгжиж буй орнуудын тоонд багтдаг манай орны хувьд энэ бол том амжилт гэдэг нь тодорхой. Гэхдээ нийгэм хөгжих тусам боловсролын салбарт онцгой анхаарч, улам боловсронгуй болгох, тооноос чанарт шилжих, зарим чиглэлд эрс өөрчлөлт шинэчлэл хийх шаардлага тулгарсаар байна.

Өнөөдөр дэлхий дахины дээд боловсролын хөгжилд хоёр том чиг хандлага хүчтэй ажиглагдах болсон. Нэг дэх нь дээд боловсролын глобалчлал буюу даяаршил бол хоёр дахь нь дээд боловсролыг ардчилах буюу багш төвтэй сургалтаас шавь төвтэй сургалт руу шилжиж, иргэд хүссэн мэргэжил, сургууль, багшийг хүртэл чөлөөтэй сонгож, үзэх хичээлийн дараалал, цаг

хугацааны хамаарал харьцангуй уян хатан байх явдал юм.

Даяаршлын үйл явц бол соёл иргэншлийн янз бүрийн саад бэрхшээлийг даван туулж, нийгмийн, оюуны, ахуйн, улс төрийн үйл ажиллагааны бүх төрлийн хэм хэмжээ, стандартыг тэгшитгэх зорилго агуулдаг. Энэ нь үйл явц болохын хувьд улс дамжсан соёл иргэншлийн харилцаа, харилцан нөлөөлөл, үнэт зүйлс оршин тогтнох, хүчтэй болохыг чухалчилдгаараа онцлогтой юм. Одоо нийгмийн өвөрмөц институт болох сэтгүүл зүйн боловсон хүчнийг бэлтэх, сэтгүүл зүйн сургалтыг боловсронгуй болгох асуудлыг дэлхий дахины дээд боловсролын хөгжилд ажиглагдаж буй хандлагуудтай холбон тайлбарлахыг оролдъё.

Өнөөдөр мэдээлэл, түүний дотор сэтгүүл зүйн мэдээллийн ач холбогдол эрс өсөн нэмэгдэж, түүнийг хүн төрөлхтний амьдралд энерги, материйн нэгэн адил үүрэг гүйцэтгэдэг язгуур ойлголт гэж үздэг болжээ. Тиймээс XXI зууныг мэдээллийн эрин гэдгийг дэлхий дахинд хүлээн зөвшөөрсөн билээ. Үүнд сэтгүүл зүй хэмээх өвөрмөц нийгмийн институт онцгой үүрэг гүйцэтгэх болно. Энэ нь дэлхийн сэтгүүл зүй

хөгжлийн гол хандлага болох даяаршил, төвлөрөл, ижилсэл, эс олон нийтжилттэй шууд холбоотой юм. Орчин үед цахим сэтгүүл зүй энгийн үзэгдэл болж, иргэний сэтгүүл зүй орж ирж байгаа нь сэтгүүл зүйн сургалтанд өөрөөр хандаж, эрс өөрчлөлт хийх шаардлага тавигдаж байна. Нөгөө талаар дээд боловсролын системд гарч буй өөрчлөлт, түүний хөгжлийн чиг хандлага зөвхөн сэтгүүл зүйн төдийгүй бүх төрлийн сургалтын агуулга, арга хэлбэр, субъектын үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлөх болсон. Энэ бүхэн нь дараах хэд хэдэн хүчин зүйлтэй шууд холбоотой юм.

Нэгдүгээрт, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн өсөлт маш эрчимтэй явагдаж, нийгмийн аль ч салбар хэвийн үйл ажиллагаа явуулахын тулд нийт ажиллагсадын 50-аас доошгүй хувь нь дээд боловсролтой байхыг шаардах болсон. Энэ үзэгдэл их, дээд сургуулийн тоо эрс өсөн нэмэгдэхэд нөлөөлж байна. Манай оронд өнөөдөр 98 (төрийн 16, хувийн 76, гадаадын хөрөнгө оруулалттай 6) их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байгаагийн 18-д нь сэтгүүлч бэлтгэж байна.

Хоёрдугаарт, шинжлэх ухаан технологийн мэдээллийн өсөлт хурдтай явагдаж, сүүлийн 10 жилд 3 дахин нэмэгдсэн. Энэ бол тасралтгүй явагдах боловсрол, мэргэжил дээшлүүлэх, давтан бэлтгэх асуудлыг хурцаар тавьж байна. Харин манай орны сэтгүүл зүйн сургалтанд ийм хандлага огт ажиглагдахгүй байна.

Гуравдугаарт, технологийн маш хурдтай өөрчлөлт мэргэжлийг өөрчлөх, мэргэжилтэнд эрс өөрөөр хандахад хүргэж байна. Хос мэргэжилтэй, нэг чиглэлийг дагнасан боловч өргөн

хүрээний мэргэжилтэн бэлтгэх шаардлага гарлаа. Сэтгүүлч гэсэн ерөнхий нэрээр биш, сэтгүүлч-эрх зүйч, сэтгүүлч-эдийн засагч, сэтгүүлч-улс төрч гэх мэт чиглэл, мөн сэтгүүл зүйн дотор нарийн мэргэшүүлэх, сэдэв чиглэлээр төрөлжүүлэн бэлтгэх нь орчин үеийн ОНМХ-ийн хэрэгцээ, шаардлагад нийцэх болно. Нөгөө талаар биеийн ба оюуны хөдөлмөрийг автоматжуулахад чиглэгдсэн оюуны үйл ажиллагааны хэрэгслүүд бий болж байна. Энэ нь шинийг санаачлагч, шинэчлэгч мэргэжилтнүүдийн тоо өсөхөд нөлөөлж, хэвлэл мэдээллийн хэрэгслийг компьютержүүлэх, зөвхөн сэтгүүлч төдийгүй бусад янз бүрийн мэргэжилтнүүд ажиллах шаардлага гарч эхэлсэн. Тиймээс зөвхөн сэтгүүлч-уран бүтээлч бус, сэтгүүлч-инженер, сэтгүүлч-программ зохиогч, сэтгүүлч-эдийн засагч, сэтгүүлч-менежмент зэрэг хос мэргэжлээр бэлтгэх нь сэтгүүл зүйн сургалтын тулгамдсан асуудал болж байна.

Дөрөвдүгээрт, янз бүрийн шинжлэх ухааны зааг дээр хийгддэг эрдэм шинжилгээ, судалгааны ажил тэргүүн зэрэгт тавигдаж, биофизик, молекулын генетик, физикийн хими, акмеологи зэрэг чиглэлүүд тэргүүлэх байр эзлэх болов. Мөн сэтгүүл зүйн судлалд ч эрс өөрөөр хандаж, бусад шинжлэх ухаантай холбон судлах, тодорхой асуудлын хүрээнд гүнзгийрүүлэн судлах шаардлага гарч байна. Үүнийг ялангуяа магистр, боловсролын докторын сургалтад түлхүү анхаарах, ирээдүйн багш-судлаач бэлтгэхэд харгалзан үзэх хэрэгтэй юм.

Тавдугаарт, үйл ажиллагааны нэлээд явцуу, нарийн түвэгтэй салбарт ажиллах, оролцох янз бүрийн

мэргэжлийн хүмүүсийн тоо нэмэгдсэн нь эрдэмтэн судлаачдын оюуны дундаж чадавхийг бууруулахад нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, цоо шинэ мэргэжлийн хүмүүс орж ирсэн нь хуучин ажилтнуудыг орчин үеийн мэдлэг, мэдээллээр хангахыг хүчтэй шаардах болсон. ОНМХ-ийн салбарт гарч буй өөрчлөлт, чиг хандлага нь сэтгүүлчдийг шинэ мэдлэгээр цэнэглэх, мэдээлэл хүлээн авах боломжийг өргөтгөхийн хамт тэдний хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах шаардлагатай болж байна. Дээрх хүчин зүйлээс шалтгаалан өнөөдөр дэлхий дахины болон манай дээд боловсролын системд дараах чиг хандлагууд ажиглагдаж байна. Үүнд:

- Дээд боловсролыг ардчилах үйл явц нэлээд хүчтэй өрнөж, түүний тодорхой илрэлүүд манай дээд боловсролын сургалтанд мэдэгдэхүйц үр дүнгээ өгч байна. Өөрөөр хэлбэл, иргэд мэргэжил, сургууль, сургалтын хэлбэр, багш нарыг хүртэл сонгох, сургалтын хугацааг уян хатан зохицуулах боломжтой болсон. Нөгөө талаар сургалтын шууд ба эргэх холбоо идэвхжиж, багш төвтэй сургалтаас шавь төвтэй сургалт руу шилжиж байгаа нь боловсролыг ардчилахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

- Боловсролыг хүнлэг энэрэнгүй, хүмүүнлэг шинжтэй, агуулгатай болгох нь тэргүүн зэргийн шаардлага болж, аль нэг мэргэжлийн (ялангуяа техни-

кийн, байгалийн ухааны) хэт нэг талыг барьсан явцуу шинжийг арилгах, хүмүүнлэгийн ухаантай холбох талаар идэвхтэй алхам хийж эхэлсэн. Энэ нь нийгмийн ухааны, нийгэм-эдийн засгийн хичээлийн тоо, эзлэх хувийг нэмэгдүүлэх, мөн энэ чиглэлийн сургуулийн тоо өсөхөд нөлөөлж байна. Дэлхийн дээд сургуулиудад ийм хичээлүүд нийт хичээлийн 30-аас доошгүй хувийг эзэлдгийг судлаачид тэмдэглэсэн байдаг¹. Манай орны нийт их, дээд сургуулийн 70 гаруй хувийг хүмүүнлэгийн чиглэлийн сургууль эзэлдгийн дотор сэтгүүлч бэлтгэдэг сургууль 18 байгааг дээр дурдсан.

- Боловсролыг суурь шинжтэй болгох, өөрөөр хэлбэл эзэмших ёстой үндсэн мэргэжлийн да-

гуу сайн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн бэлтгэлийг сайжруулах асуудалд түлхүү анхаарч эхэлсэн. Сайн суурь бэлтгэлгүйгээр сайн мэргэжилтэн төрөхгүй гэдгийг гол чиг баримжаа болгох шаардлага тулгарч байна. Харамсалтай нь манай сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиудад энэ ажил туйлын хангалтгүй байна. Багшлах боловсон хүчин, сурах бичиг, материал-техникийн бааз, дадлагажих мэдээллийн хэрэгсэл, уншлагын болон хичээлийн танхим хүрэлцэхгүй байгаагийн хамт элсэгчдэд тавих шаардлага, элсүүлэх шалгуур нэлээд сул байгаа нь үүнд нөлөөлөх гол хүчин зүйл юм.

- Оюутны хувийн онцлог, чиг баримжаа, авьяас чадвар, суурь боловсро-

«

ОНМХ-ийн салбарт гарч буй өөрчлөлт, чиг хандлага нь сэтгүүлчдийг шинэ мэдлэгээр цэнэглэх, мэдээлэл хүлээн авах боломжийг өргөтгөхийн хамт тэдний хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах шаардлагатай болж байна.

»

лын түвшнийг харгалзаж боловсрол олгох. Энэ бол сонгон суралцах, сонгон мэргэшэх, ганцаарчилсан хөтөлбөрөөр хичээллэх, сургалтын экстернат хэлбэрийг сонгох, бие дааж гүйцэтгэх даалгавар, ажлын цагийг нэмэх, багш оюутны албаны бус харилцааг бэхжүүлэх, шавь сургалтыг хөгжүүлэх явдал юм. Сэтгүүлч бэлтгэхэд дээрх сургалтын хэлбэр онцгой үүрэгтэй. Учир нь сэтгүүлчийн мэргэжил бол практик чиг баримжааг түлхүү анхаардаг өвөрмөц мэргэжил мөн. Харин манай сэтгүүлч бэлтгэдэг сургуулиуд дээрх сургалтын аргуудыг жигд ашиглаж чадахгүй байна.

• Дээд боловсролыг компьютержүүлэх асуудал бол өнөөдрийн их, дээд сургуулиудын хамгийн гол, тулгамдсан зорилтуудын нэг юм. Сургалтын автоматжуулсан систем дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад энгийн үзэгдэл болоод удаж байна. Харин манайд дөнгөж эхлэл төдий зүйл. Энэ бол багш оюутнууд өргөн хүрээний мэдээлэл хүлээж авахын хамт мэдлэгийн хүрээг өргөжүүлэх, мэдээлэл солилцох, мэдлэгийг компьютерийн тестээр шалгах, алсын зайны сургалт явуулах, мэдээллийн төрөлжсөн сантай болох боломжийг бүрдүүлдэг. Сэтгүүлч хүний хувьд үүнээс гадна эх бичвэрийг шууд боловсруулах, дизайн-загвар хийх, мэргэшсэн чиглэлийн мэдээллийн сантай болох, санхүүгийн программыг ашиглах замаар шаардлагатай эх сурвалж олж авахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Компьютерийн тоо оюутны тооноос давсан тохиолдолд орчин үеийн автоматжуулсан сургалтыг өндөр түвшинд явуулах боломжтой гэж үздэг. Манайд ийм боломж одоохондоо бүрдээгүй байгааг хэлэх нь зүйтэй. Тэр

ч байтугай багш болгон тусдаа компьютер эзэмших боломж ч хараахан бүрдээгүй байна.

• Шинжлэх ухаан-сургалт-үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах нь дээд сургуулийн үйл ажиллагааны өвөрмөц хэлбэр юм. Цөм нь сургалтын салбар, их сургууль, бүрхүүл нь бааз-коллеж, бизнес-сургуулиуд, дээд сургуулийн дараах сургалт байдаг. Үйлдвэрлэлийн салбар нь туршилтын үйлдвэр, туршлага нэвтрүүлэх пүүс, хоршоо, зохион бүтээх товчоо юм. Үүнийг сэтгүүл зүйн сургалтанд нийцүүлэн өгүүлбэл сэтгүүлч бэлтгэдэг дээд сургуулийн дэргэд лицей сургууль байгуулах, дараа нь магистр, боловсролын докторын сургалттай байхын хамт дадлагын бааз болох хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх шаардлагатай.

Энэ бол сургуулийн, эсвэл хамтран ажиллах байгууллагын сонин хэвлэл, сургалтын радио, телевизийн студи мөн. Ийм дадлагын баазтай болоогүй нөхцөлд сайн сэтгүүлч бэлтгэх боломжгүй юм.

• Өнөөдөр дэлхий дахинд бүх нийтээрээ дээд боловсрол эзэмших хандлага хүчтэй өрнөж байна. Үүнд төр засгийн зүгээс байнга анхаарч, тодорхой бодлого, үзэл баримтлалын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах болсон. 2000-2008 онд Испани дээд боловсролд зарцуулах хөрөнгийг 10 дахин, АНУ 5 дахин нэмэгдүүлжээ. Дэлхийн өндөр хөгжилтэй оронд оюутны өсөлт 5-10% нэмэгдэж, АНУ-д дунд сургууль төгсөгчдийн 57%, Японд 40% нь дээд сургуульд элсэн суралцаж байна². Манайд дээд сургуулийн тоо, элсэгчдийн тоо нэмэгдэж байгаа боловч зарцуулах хөрөнгийн хэмжээ дэндүү бага байна. Нөгөө талаар дээд

сургуулийн сургалтын чанар, агуулгад тавих хяналтын механизм алга байна. БШУЯ-нд сэтгүүл зүйн сургалтыг мэддэг нэг ч мэргэжилтэн алга байгаа нь сэтгүүл зүйн сургалт урсгал шинжтэй, чанаргүй явагдахад нөлөөлж буй нэг гол хүчин зүйл юм.

- Сургалтын материаллаг баазыг эрс сайжруулах, автоматжуулах, өөрөө өөрийгөө удирдах системд шилжих, удирдлагыг сонгуулиар сонгох системд шилжих нь сургалтыг сайжруулах нэг гол хөшүүрэг мөн. Манай ихэнх их, дээд сургуулийн менежмент сул, шууд ба эргэх холбоо тааруу, ил тод, олон ургальч зарчим үгүйлэгдэж байна.

- Багшлах боловсон хүчнийг эрс сайжруулах, мэдлэг боловсролыг байнга дээшлүүлэх, давтан бэлтгэх асуудал дээд сургуулийн чанарын хэмжүүр болж, сурган-сэтгэл судлалын судалгааны ач холбогдол нэмэгдэж байна. Багшийн ажлын гол шалгуур нь багшлах ажил, эрдэм шинжилгээний ажил, нийгмийн идэвх байх бөгөөд багш нарын рейтингийг дээрх шалгуурын дагуу тогтоох шаардлагатай. Ийм хяналт, шалгалт тогтоохгүйгээр дээд боловсролын сургалтыг сайжруулах боломжгүй юм.

- Нийгмийн зүгээс дээд сургуулийн ажлын үр нөлөөг тогтмол үнэлэх систем тогтоож, хэвшүүлэх. Энэ бол рейтинг тогтоох, чанарын үнэлгээ өгөх төрийн бус байгууллага байдаг бөгөөд ийм нэгж өндөр хөгжилтэй орнуудад чухал үүрэг гүйцэтгэдэг. Манайд Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл нэртэй байгууллага байгаа боловч тэр нь Боловсролын төрийн байгууллагын харьяанд байгаа нь учир дутагдалтай юм. Үйл ажиллагаанд захиргаадалтын нь хэт давамгайлсан шинжтэй байна.

Энэ бүхэн нь манай зарим сургуульд эхлэл төдий байгаа бол зарим сургуульд огт нэвтрээгүй байна. Дээд боловсролтой боловсон хүчин бэлтгэх ажлыг дэлхийн стандартын түвшинд ойртуулахын тулд дараах хэдэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа нь ажиглагддаг. Энэ бол:

Нэгдүгээрт, дээд боловсролын талаар чиглэсэн зорилготой, оновчтой, шинжлэх ухааны үндэслэл сайтай төрийн бодлого байх хэрэгтэй. Дээд боловсролын үзэл баримтлалыг боловсруулж, одоогийн мөрдөж байгаа Боловсролын тухай багц хуулиудыг шинэчлэх, боловсронгуй болгох. Боловсролын тухай нийгмийн санаа бодлыг зөв төлөвшүүлэх, боловсролыг эрхэмлэх сэтгэл зүйн бэлтгэлтэй болгох, өөрөөр хэлбэл боловсрол чухал гэдгийг нийгмийн бүх давхарга гүнзгий ойлгосон байх ёстой юм. Манай орны хувьд өнөөдөр ийм ойлголт жигд биш, ялангуяа хөдөө орон нутагт боловсролд хандах хандлага нэлээд доогуур түвшинд байгааг анхаарвал зохино.

Хоёрдугаарт, боловсролын үйлчилгээг зах зээлийн харилцаанд тохируулан боловсронгуй болгож, өрсөлдөөн бий болгох нь чухал. Боловсрол зах зээлтэй "халз тулсан" байдалтай байх ёсгүй. Үүнд татаас, хөрөнгө оруулалт, татварын хөнгөлөлт чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ бол төрийн бодлогын төвд байх ёстой амин чухал асуудал юм.

Гуравдугаарт, дээд боловсролын үзэл баримтлалд "боловсрол-шинжлэх ухаан-бизнес" чухал байр эзлэх ёстой бөгөөд боловсролыг хөгжүүлэхэд тухайн орны бүс нутгийн онцлогийг харгалзан үзэх шаардлагатай.

Дөрөвдүгээрт, боловсролын бүх шатанд хяналтын системийг нэвтрүүлэх. Ийм хяналтын ажлыг хэрэгжүүлэх механизм нь маш оновчтой, үр нөлөөтэй байхын хамт хариуцах байгууллага нь нэр хүндтэй, үр нөлөөтэй байх шаардлагатай.

Тавдугаарт, дээд боловсролын үзэл баримтлал, төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд орчин үед дэлхий дахинд баримталж буй Германы Гумбольдтын "судалгааны их сургууль" буюу нэгдүгээр ангиас нь эхлээд эрдэм шинжилгээ, сургалт хоёрыг шууд хослон явуулдаг сургалтын хэлбэр, Британийн Оксбрижийн загвар буюу оюутны бие даасан байдлыг дээд зэргээр хангаж, багш оюутны албан ёсны бус харилцаанд тулгуурласан сургалт (үүнийг тьютерийн сургалт гэдэг), Францын "том сургууль"-ийн загвар буюу судалгааг гол болгодоггүй, элит боловсон хүчин бэлтгэхэд чиглэгдсэн чанартай сургалт, АНУ-ын Чикагогийн загвар буюу хүмүүнлэгийн ухааныг тэргүүн байранд тавьдаг ардчилсан шинжтэй, өргөн хүрээний мэдлэг олгоход чиглэгдсэн сургалт зэрэг дээд сургуулийн үндсэн дөрвөн загварыг харгалзан үзэх шаардлагатай. Өнөөдөр дээрх дөрвөн загварыг дэлхийн бараг бүх оронд ямар нэг хэмжээгээр баримталдаг бөгөөд ихэнх тохиолдолд хосолсон загваруудыг хэрэглэдэг байна.

Одоо бидний өгүүллийн үндсэн асуудал болох сэтгүүл зүйн сургалтын талаар тогтож ярья.

Дэлхий дахинд сэтгүүл зүйн сургалт XIX зууны 90-ээд оноос Герман, Франц, Англи, Швейцарь зэрэг оронд эхэлж, сэтгүүл зүйн анхны дээд сургууль 1902 онд Жозеф Пулитцерийн санаачилгаар Америкийн Колумбын их сургуулийн

харьяанд байгуулагджээ³. Монгол улсад 1960 оны намар МУИС-ийн Хэл бичгийн факультетэд сэтгүүлчийн ангийг нээж, анхны 32 хүнийг элсүүлснээр сэтгүүл зүйн сургалтын эх суурь тавигдсан билээ. 1964 онд 30 хүн тус сургуулийг амжилттай төгсөж, сэтгүүлчийн мэргэжлийн дипломыг гардан авснаар манай орны сэтгүүл зүйн салбарт үндэсний сэтгүүлч боловсон хүчин ажиллаж эхэлсэн түүхтэй юм⁴. Түүнээс хойш 53 жил өнгөрч, зөвхөн МУИС-ийг 1200 орчим хүн сэтгүүлч, олон улсын сэтгүүлч, сэтгүүлч-монгол хэлний багш мэргэжлээр төгссөн байна. Энэ бол өнөөдөр Монголын сэтгүүл зүйн салбарт ажиллаж буй нийт сэтгүүлчдийн 1/3 нэг гэсэн үг юм.

1990 оны Ардчилсан хувьсгал Монголын сэтгүүл зүй дэх асар том өөрчлөлт шинэчлэлийн эхлэлийг тавьж, ОНМХ-ийн систем, нийтлэл нэвтрүүлгийн агуулга, бичлэгийн төрөл зүйл, ур чадвар, хэвлэл мэдээллийн менежментэд урьд өмнө үзэгдэж байгаагүй цоо шинэ зүйлийг авч ирсэн билээ.

Аливаа орны сэтгүүл зүйн үнэт капитал болсон боловсон хүчингүйгээр ОНМХ-ийн ямар ч үйл ажиллагааг төсөөлөх боломжгүй учир юуны өмнө сэтгүүлч боловсон хүчнийг бэлтгэх, давтан бэлтгэх, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, бусад улс орны сэтгүүлчдийн ажлын туршлага, арга барилаас суралцах шаардлага хурцаар тавигдсан. Энэ асуудлыг нааштай шийдвэрлэхийн тулд олон талт ажил зохион байгуулагдсаны дотор сэтгүүлч бэлтгэж буй их, дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг цаг үеийн шаардлагад нийцүүлэх, дахин шинэчлэн боловсруулах, чанарын шинэ шатанд гаргах

талаар идэвхтэй алхам хийсэн явдал чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Манай оронд үндэсний их, дээд сургуулиар сэтгүүлч мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлснээс хойшх хагас зуун жилийн хугацаанд тухайн мэргэжлийн сургалтын арга барил үндсэндээ төлөвшиж, сэтгүүл зүй өндөр хөгжсөн орнуудын туршлага, нийгмийн шинэ харилцааны явцад урган гарсан шаардлага зэргийг тусган баяжсаар байгаа билээ.

1990 оноос хойш улсын болон хувийн их дээд сургууль, коллежүүд сэтгүүлч бэлтгэх болсон нь зах зээлийн харилцааны жам ёсны үйл явц юм. Гэвч сэтгүүл зүйн сургалтанд багагүй бэрхшээл тулгарч байна. Үүнийг хамгийн гол нь мэргэжил эзэмших эрэлт хэрэгцээг хангасан, уламжлал шинэчлэлийг хосолсон хичээлийн төлөвлөгөө, стандарт, дээр нь сургалтын баримт бичигт тусгасан хичээлүүдийг онол, практикийн өнөөгийн шаардлагын түвшинд зааж чаддаг багшлах боловсон хүчин дутмаг байгаагаар холбоон талбарлаж болно. Энэ нь урсгал шинжтэй сургалт явуулж байгаагийн, бас чанаргүй боловсон хүчин олноор төрөн гарч байгаагийн нэг гол шалтгаан болж байна.

Өнөөдөр Улаанбаатар болон бусад хотод улсын болон хувийн 18 сургуульд сэтгүүлч бэлтгэж байгаа боловч орчин үеийн шаардлага хангасан сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөртэй сургууль хуруу дарам цөөн байна. Олонх сургууль заагдах хичээлийн тодорхойлолт, дадлагын болон төгсөлтийн ажил, курсын ажлын удирдамж, заавар зэрэг наад захын баримт бичиггүй барагцаагаар явж ирсэн нь Соросын

сангийн ивээл дор явуулсан "Сэтгүүл зүйн сургалтын өнөөгийн байдал", "Сэтгүүл зүйн сургалтын агуулгыг сайжруулах нь" зэрэг төслийн судалгаагаар тодорхой харагдсан юм. Ялангуяа зарим хувийн сургуульд мэргэжлийн мэдлэг туршлага сайтай орон тооны багшгүйгээс практик ажилтнуудыг урьж, хичээл заалгадаг бөгөөд тэд сургалтын технологи мэдэхгүй учраас сургалт ямар нэг тодорхой зорилго, агуулга, логик дараалалгүй, урсгал шинжтэй явагддаг байна. Нөгөө талаар сэтгүүлч мэргэжлийг өөр мэргэжилтэй хослон эзэмшүүлэх нэрээр сургалтын агуулга, стандартыг ихээхэн зөрчиж байна. Тухайлбал, орчуулагч-сэтгүүлч, спортын сэтгүүлч, сэтгүүлч-рекламын менежер, улс төрч-сэтгүүлч, англи хэлний орчуулагч-сэтгүүлч гэх зэрэг мэргэжлээр диплом авч төгссөн оюутан нь сэтгүүлч болоход зайлшгүй шаардлагатай хичээлүүдийн тал хувийг ч үзээгүй байдаг. Үзсэн ч маш цөөн цагаар, мэргэжлийн хангалтгүй түвшинд судалдаг байна.

Сэтгүүл зүйн онолын үндсэн ойлголтуудыг ч сургууль бүр жигд, нэг мөр өгч чадахгүй байгаа нь сургалтын хөтөлбөрийг чанартай хийдэггүй, багшлах боловсон хүчний мэдлэг туршлага дутмаг зэрэг асуудалтай холбоотой юм. Иймд сэтгүүлч бэлтгэж байгаа их, дээд сургууль, коллежүүдэд тухайн мэргэжлийг эзэмшихэд зайлшгүй биелүүлвэл зохих сургалтын ажлын нэгдсэн стандартыг мөрдүүлэх шаардлага урган гарсан билээ.

1994 оноос сэтгүүлч бэлтгэх шаталсан сургалтын тогтолцоонд шилжин сэтгүүл зүйн бакалавр (BA), сэтгүүл зүйн магистр (MA), сэтгүүл зүйн доктор (Ph.D)-ын зэрэгтэй ОНМХ-ийн ажилт-

нуудыг бэлтгэж эхэлсэн байна. Үүнтэй холбоотой дэлхий дахины дээд боловсролын системд өргөн хэрэглэж буй кредит цагийн системд шилжиж, 120-128 кредит цагийн мэдлэг эзэмшсэн бол бакалавр, $128+32=160$ кредит цагийн мэдлэг эзэмшиж, магистрын дипломын ажил бичиж хамгаалсан бол сэтгүүл зүйн магистр (МА), $160+50=210$ кредит цагийн мэдлэг эзэмшиж, докторын диссертаци бичиж хамгаалсан бол сэтгүүл зүйн доктор (Ph.D)-ын боловсролын зэрэг эзэмших болсон. Ийм тогтолцоог хэрэгжүүлэх зорилгоор Боловсролын сайдын тушаалаар 1995 онд МУИС-ийн дэргэд Сэтгүүл зүйгээр докторын зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөлийг байгуулж, энэ зөвлөл 2007 оны 9 дүгээр сарын 1 хүртэлх хугацаанд 10 гаруй хүний эрдмийн ажлыг хамгаалуулж, сэтгүүл зүй судлалыг хөгжүүлэх талаар багагүй ажил хийж гүйцэтгэсэн. Эрдмийн зэрэг хамгаалуулах журам өөрчлөгдсөн учраас тус зөвлөл 2007 оны 9 дүгээр сарын 1-нд татан буугдаж, үйл ажиллагааныхаа чиг үүргийг МУИС-ийн дэргэд байгуулагдсан Утга зохиол, сэтгүүл зүйн докторын хороонд шилжүүлсэн бөгөөд энэ хороо 2010 оны 12 дугаар сар хүртэл ажиллаж байгаад эрдмийн зэрэг хамгаалуулах шинэ журам гарсантай холбоотой татан буугдсан юм. 2011 оноос БСШУЯ-ны шийдвэрээр МУИС-ийн дэргэд Нийгмийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалах нэгдсэн зөвлөлтэй болсон бөгөөд өнөөдөр сэтгүүл зүй, философи, социологи, улс төр, шашин судлал гэсэн 5 мэргэжлийн докторант, эрдмийн зэрэг горилогчид энэ зөвлөлд эрдмийн зэрэг хамгаалж байна.

Манай орон нийгмийн шинэ тогтолцоонд шилжиж, боловсролын сургалтын шинэ бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотой 2000 оноос дээд боловсролын мэргэжлийн стандартыг боловсруулж, 2004 оны 12 дугаар сард "Сэтгүүлч" мэргэжлийн стандартыг Стандарт хэмжил зүйн үндэсний зөвлөлөөр баталж 2005 оны 1-р сараас орон даяар мөрдөж эхэлсэн.

Энэ бол манай оронд СХЗҮ-ийн зөвлөлөөр батлагдсан анхны хоёр стандартын нэг байсан юм. Ийм стандарт дэлхийн аль ч орны боловсролын салбарт байдаг бөгөөд гол зорилго нь тухайн мэргэжилтнийг бэлтгэхэд бакалаврын түвшинд зайлшгүй эзэмших ёстой мэдлэг, чадварын минимум хэмжээг тогтоож өгөхөд оршино. Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүйн чиглэлээр олгох бакалаврын боловсролын агуулга, түүний үнэлгээ, сургалтын хугацаа, сургалтын орчинд тавих үндсэн (наад захын) шаардлагыг баталгаажуулж, дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны бие даасан байдлыг хангаж, сургалт олон хувилбартай байх нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын "Боловсролын тухай хууль", "Дээд боловсролын тухай" хуулийн хүрээнд сэтгүүл зүйн бакалаврын зэргийн боловсролын агуулга, сургалтын орчны нийтлэг шаардлагуудыг тогтоосон болно.

Дээд боловсролын стандарт гэдэг нь "Боловсролын тухай" хуульд зааснаар "дээд боловсролын агуулга, түүний үнэлгээ, багшийн мэргэжлийн түвшин, сургалтын байгууллагад тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох баримт бичиг"⁵ юм. Энэхүү стандартын ач холбогдол нь:

- Сэтгүүл зүйн бакалаврын боловсролын агуулгыг бүрдүүлдэг тухайн мэргэжлийн тодорхойлолт, сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийн хөтөлбөр, дадлагын хөтөлбөр-удирдамжийг тодорхойлж, эдгээр баримт бичгүүдийг чиглэсэн зорилготой, шинжлэх ухааны үндэстэй боловсруулах боломжийг олгох,

- Тухайн мэргэжлийн зориулалт, төгсөгчдийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлох,

- Дээд боловсролын сургалтын зохион байгуулалт, агуулга, багтаамж, судлах хичээлийн цэс, тэдгээрийн багтаамж, дараалал, тодорхойлолт, дадлагын төрлийг оновчтой тусгах,

- Хичээл тус бүрээр эзэмшвэл зохих, онол, практикийн мэдлэг, чадвар, дадал, хандлагын агуулга, үнэлгээ, хичээлийн багтаамж, ашиглавал зохих ном, сурах бичгийн жагсаалтыг тодорхойлох,

- Сургалтын үйл явцын тасралтгүй байх, хичээлүүдийн залгамж чанарыг хадгалах, сургалтын чанар, үр өгөөжийг болон мэргэжилтний хөрвөх чадварыг дээшлүүлэх,

- Сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалт, судалгааны ажлын уялдаа холбоог сайжруулж, төгсөгчдөд тавигдах мэдлэг боловсрол, дадал чадварын нийтлэг шаардлагуудыг жигдрүүлэх, нийгмийн өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг хангахуйц боловсон хүчин бэлтгэх боломжийг бүрдүүлэхэд оршино.

Сэтгүүл зүйн сургалтын стандартыг боловсруулахдаа БСШУЯ-наас боловсруулсан Үлгэрчилсэн журам, тавигдах ерөнхий шаардлагуудыг иш үндэс болгохын хамт дэлхийн өндөр хөгжилтэй зарим орны (АНУ, ОХУ, Герман

г. м.) дээд боловсролын стандарттай танилцаж, тэдний баримталдаг ерөнхий зарчим, үзэл баримтлал, шаардлагуудыг харгалзан үзсэн болно. Энэхүү стандарт нь дараах хэд хэдэн онцлог шинжийг агуулдаг. Үүнд:

- Уг стандарт нь дөрвөн жилийн сургалттай сонгон мэргэших чиглэлээр ямар нэгэн нарийн мэргэжлийг эзэмшсэн "сэтгүүлч бакалавр" гэсэн ерөнхий мэргэжлээр төгсөгчдийг бэлтгэх түвшинд хийгдсэн.

- Стандартын агуулга нь Ерөнхий суурь (А), Мэргэжлийн суурь (Б), Мэргэшүүлэх хичээл (В), Үйлдвэрлэлийн дадлага (Г) гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрддэг. Ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагчдад дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх зорилготой бөгөөд Заавал судлах хичээл (А1), Сонгон судлах хүмүүнлэгийн ухааны хичээл (А2), Сонгон судлах нийгмийн ухааны хичээл (А3) гэсэн үндсэн гурван хэсэгтэй юм.

Мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь сэтгүүл зүйн чиглэлээр мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай онол, практик, арга зүйн мэдлэг эзэмшүүлэх зорилготой 18-20 хичээл байна. Мэргэших хэсгийн агуулга нь оюутнуудад нийгмийн өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сэтгүүлч мэргэжлээр мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх зорилготой бөгөөд Заавал судлах хичээл (В1), Сонгон мэргэших хичээл (В2) гэсэн бүтэцтэй байна. Стандартад дээр дурдсан хэсгүүдийн багц цагийн кредит цагийн харьцааг ойролцоогоор А:Б:В:Г=40-42:50-52:28-32:5 хийгдсэн байгаа. Харин Ерөнхий суурь хичээлийн багц цагийг Боловсролын асуудал

хариуцсан төрийн төв байгууллагаас тогтоож өгсөн байдаг.

- Дөрвөн жилийн дотор нийт 128 кредит (багц) цагийн мэдлэг олж авах ёстой бөгөөд хос мэргэжлээр сэтгүүлч-рекламын менежер, сэтгүүлч-орчуулагч, сэтгүүл-улс төрч г.м. сургалт явуулж байгаа нөхцөлд мэргэжлийн хичээлийн 10 хүртэл хувийг, өөрөөр хэлбэл, сонгож үзэх болон сонгон мэргэших хичээлүүдийг үзэхгүй байж болно. Энэ бол тухайн сургууль энэ цагийн оронд өөрийнхөө онцлогт тохируулан өөр хичээлүүдийг үзэж болно гэсэн үг.

- Энэ стандартыг боловсруулахдаа дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын сэтгүүлч бэлтгэдэг туршлагыг харгалзан үзэж, практикийн сургалт, онолын хичээлийн харьцааг 55:45 байгаар тооцож хийсэн болно.

- Дөрвөн жилийн хугацаанд үйлдвэрлэлийн дадлагыг 3-аас доошгүй удаа хийх нь чухал. Учир нь оюутан нийтлэл бичих, нэвтрүүлэг бэлтгэх арга барил, мэдээллийн газрын үйл ажиллагаатай танилцаж, ур чадвараа дээшлүүлэхэд дадлага онцгой үүрэг гүйцэтгэх бөгөөд нийт хугацаа нь 20 долоо хоногоос бага байж болохгүй юм.

- Энэ стандартад бичигдсэн хичээлүүдийн тодорхойлолт, хөтөлбөр, дадлагын ажлын удирдамж, ангийн болон төгсөлтийн ажил бичих зөвлөмж зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, сургалтыг тэдгээрийн үндсэн дээр явуулах шаардлагатай.

- Стандартад урьд өмнө манай оронд заагдаж байгаагүй орчин үед зайлшгүй шаардлагатай олон шинэ хичээлийг оруулж өгснөөрөө дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын дээд боловсролын стандартын түвшинд

дөхөж очсон гэж хэлж болно. Тиймээс ч 2004 онд Стандарт хэмжил зүйн үндэсний зөвлөлийн хурлаар батлагдсан дээд боловсролын мэргэжлийн анхны хоёр стандартын нэг болсон юм.

Энэ стандарт батлагдсанаас хойш 7 жил өнгөрч, 8 дахь жилийн нүүр үзэж байна. Сэтгүүлч бэлтгэдэг олон сургууль өнөөдөр стандартын дагуу сургалтын үйл ажиллагааг явуулж энэ хугацаанд цаашид улам боловсронгуй болгох, засаж залруулах зүйл ажиглагдсан юм. Нөгөө талаар 5 жил тутам стандартын үзлэгийг хийж, нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгохыг уг стандартад тусгасан байна.

Стандарт батлагдсанаас хойш хугацаанд сэтгүүл зүйн салбарт асар их юм өөрчлөгдөж, сэтгүүл зүйн шинэ чиглэлүүд хүчтэй нэвтэрч, дэлхий дахины сэтгүүл зүйд ажиглагдаж буй даяарчлал, төвлөрөл, ижилсэл, эс олон нийтжилт зэрэг хөгжлийн хандлагууд манай орны сэтгүүл зүйн хөгжилд нөлөөлж эхэлсэн бөгөөд зарим нь бодит үзэгдэл болсон. Энэ бол ганцхан сэтгүүл зүйн салбарт ажиглагдаж буй үзэгдэл биш, манай орны нийгэм, эдийн засаг, улс төрийн аль ч салбарт явагдаж байгаа нийтлэг хандлага юм. Тиймээс МУИС өнгөрсөн жилээс бакалаврын сургалтын төлөвлөгөөг дахин шинэчлэн баталж, энэ хичээлийн жилээс мөрдөж эхэлсэн. Энэ бол өмнөх сургалтын төлөвлөгөөнөөс зарчмын ялгаатай бөгөөд ерөнхий суурь хичээл (24 кр, заавал болон сонгон судлах хичээлүүдээс бүрдэнэ), заавал үзэх мэргэжлийн суурь хичээл (54 кр), мэргэшүүлэх хичээл (36 кр, заавал бөгөөд сонгон судлах хэлбэртэй) гэсэн бүтэцтэй.

Хамгийн гол нь энэ сургалтын төлөвлөгөөний давуу тал нь оюутанд дан үндсэн чиглэлээр мэргэших (120 кр), ижил чиглэлд хавсарга мэргэшил эзэмших (хавсарга мэргэшлийн 18 кр, сонгон судлах 6 кр судалсан байх, сэтгүүлч-ОНМХ-ийн рекламн менежер г.м.), өөр чиглэлд хавсарга мэргэшил эзэмших (24 кр нь хавсарга мэргэшлийн хичээл, сэтгүүлч-улс төр судлаач г.м.), ижил суурьтай хос мэргэжил (5 жил сурах, үндсэн мэргэшлийн 36, дараагийн мэргэшлийн 36 кр авсан байх, сэтгүүлч, социологич г.м.), өөр суурьтай хос чиглэл (7 жил сурах, бакалавр+бакалавр буюу сэтгүүлч, эрх зүйч г.м.) гэсэн 5 чиглэлээр суралцах боломж олгож байгаад оршино. Шинэ сургалтын төлөвлөгөөний дагуу оюутан төгсөхдөө бакалаврын судалгааны ажил бичиж хамгаална, эсвэл нэг нэгдсэн шалгалт өгнө. Ангийн ажлыг тусгайлан бичиж кредит авахгүй, зөвхөн зааж байгаа хичээлийн кредит дотор нь оруулж тооцох боломжтой. Оюутны мэдлэг, чадварыг үнэлэхдээ бие дааж хийж, суралцсан байдлыг хамгийн түрүүнд харгалзан үзэх болно. Энд хичээлүүдийн залгамж холбоог харуулсан сүлжээ (хичээлүүдийн мод) онцгой үүрэгтэй бөгөөд уялдаа холбоотой хичээлүүдийн аль нэгийг судлаагүй, эсвэл хангалтгүй дүн үзүүлсэн нөхцөлд дараа дараагийн хичээлүүдийг үзэх боломжгүй юм.

Ү нэлгээг А, А-, В, В-, С, С-, D, D- гэсэн дүнгээр үнэлдэг болсон. Энэ мэтийн олон өөрчлөлт гарсан учраас одоо МУИС-ийн бүх хичээлийн тодорхойлолт, хөтөлбөрүүдийг шинэчилж, үүний үндсэн дээр тухайн мэргэжлийн стандартыг шинэчлэх ажил эхэлсэн байгаа. Энэ онд

мэргэжлийн стандартаас эхлээд сургалтын бусад бүх баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж дуусах ёстой юм.

Тийм учраас энэ стандартыг боловсронгуй талаар дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Сэтгүүлч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын мэргэжлийн тэнхим, багш нарын саналыг авч нэгтгэж, хамгийн чухал гэсэн саналыг стандартад тусгах,

- Телевизийн сэтгүүл зүй, цахим хэвлэл эрчимтэй хөгжиж буйг харгалзан энэ хичээлүүдийн кредит цагийг болон танхимын дадлагын цагийг тодорхой хэмжээгээр нэмэх,

- Орчин үед сэтгүүлчдийн бичих чадвар, нэвтрүүлэгч, хөтлөгчдийн ярианы чадвар тааруу байгааг харгалзан "Орчин цагийн монгол хэл", "Найруулга зүйн онол, дадлага" зэрэг хичээлийн кредит цагийг нэмэх,

- Стандартад телевизийн сэтгүүл зүй, радио сэтгүүл зүй, цахим хэвлэлийг "Электрон сэтгүүл зүй" хэмээх ерөнхий нэрээр оруулсныг салгаж, тус тусад нь бие даасан хичээл болгон оруулж, дадлага, семинарын хичээлүүдийн цагийг нэмж, оюутны бие дааж хийх ажилд түлхүү анхаарах,

- Сэтгүүлч хүнд зайлшгүй шаардлагатай "Нийгмийн сэтгэл судлал", "Логик", "Гоо зүй", "Ёс зүй" зэрэг хичээлийг тодорхой кредит цагийн хэмжээнд зайлшгүй тусгах. Зарим сургууль стандартад тусгасан "Нийгмийн сэтгэл судлал", "Логик" зэрэг хичээлийг огт оруулахгүй, эсвэл ор нэр төдий оруулж буйг онцгой анхаарч, санаачилгатай ажиллах,

- Сэтгүүл зүйн өнөөгийн хөгжил, хандлагыг харгалзан үзэж, "ОНМХ-ийн

менежмент", "ОНМХ-ийн маркетинг", "Иргэний сэтгүүл зүй" зэрэг хичээлүүдийг нэмж оруулах,

- "Практик сэтгүүл зүй" (I, II, III), "Сэтгүүлчийн ур чадвар", "Редакторлах арга зүй", "Нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулга", "Хэвлэл мэдээллийн дизайны", "ОНМХ-ийн реклам сурталчилгаа", "Олон нийтийн харилцаа" (PR) зэрэг хичээлүүдийн хоорондох харилцан уялдаа холбоо, залгамж чанарыг сайжруулах зэрэг болно.

Гэхдээ стандартыг шинэчлэн баталснаар сэтгүүл зүйн сургалттай холбоотой бүх асуудал шийдэгдэхгүй. Сэтгүүл зүйн стандартаас гадна дараах хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна. Үүнд:

- Элсэгчдэд тавих шаардлагыг шинэ шатанд гаргах хэрэгтэй. Өнөөдөр ерөнхий эрдмийн нэгдсэн шалгалтын дүнгээр шууд элсүүлдэг болсон нь жинхэнэ авьяас чадвартай оюутан элсэх боломжийг хязгаарлаж байна. МУИС-иас бусад сургууль ур чадварын нэмэлт шалгалт авахгүй шууд элсүүлдэг. МУИС-ийн авч байгаа шалгалт нь бага оноотой учраас ерөнхий эрдмийн шалгалтын дүнд зохих нөлөө үзүүлж чадахгүй байна. Тиймээс дэлхийн сэтгүүлч бэлтгэдэг томоохон сургуулиуд хэвлэл мэдээллийн байгууллагуудад тодорхой хугацаанд ажиллаж бичих авьяас чадвараа харуулсан хүмүүсийг түлхүү элсүүлдэг, мөн их дээд сургуульд өөр мэргэжлээр суралцаж буй оюутнуудаас сонгон авч

3-р ангиас давхар суралцуулах замаар хос мэргэшилтэй сэтгүүлч бэлтгэдэг туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

- Сэтгүүл зүйн багшлах боловсон хүчинд онцгой анхаарах шаардлага тавих хэрэгтэй байна. Өнөөдөр энэ бол хамгийн тулгамдсан асуудал болж байна. Онол, практик хоёрыг жинхэнэ утгаар нь хослуулж чадсан, хэлний өндөр мэдлэгтэй багш маш ховор байна. Үндсэндээ хоёр зэрэглэлийн багш нар нэмэгдэх хандлагатай байна. Нэг хэсэг нь дөнгөж сургууль төгссөн, практик мэдлэг дутмаг залуу багш нар, нөгөө хэсэг нь өндөр насны тэтгэвэр тогтоолго-

сон ахмад сэтгүүлчид. Нэгэнд нь практик, нөгөөд нь онол, сүүлийн үеийн шинэ мэдлэг дутагдаж байгаа нь ажиглагддаг. Тиймээс сэтгүүл зүйн багш нарыг тодорхой бодлогоор бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, цалин хангамж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

- Их, дээд сургуулиудын сэтгүүл зүйн багш нарын уулзалт семинар, сэтгүүл зүй судлаачдын эрдэм шинжилгээ, онол-практикийн бага хурлыг хагас жилд нэг удаа тогтмол зохион байгуулж, сэтгүүл зүйн сургалт, судалгааны ажлын тулгамдсан асуудлуудын талаар санал солилцож, практик зөвлөмж гаргах, сэтгүүл зүйн багш, судлаачдын бүтээлийг нийтлэх эрдэм шинжилгээний хамтарсан сэтгүүлтэй болох, эсвэл МУИС-ийн Сэтгүүл зүйн

«
*Сэтгүүл зүй янз бүрийн
шинэжлэх ухаан, практик үйл
ажиллагааны шинэсийг өөртөө
агуулсан өвөрмөц нийгмийн
институт учраас түүний
боловсон хүчнийг бэлтгэх
асуудал үлэмж нарийн түвэгтэй,
багагүй хүч, хөдөлмөр, цаг
хугацаа шаардах онцлогтой.*
»

тэнхмээс жилд 1-2 удаа гаргаж буй "Сэтгүүл зүй" сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэх, үйл ажиллагааг чанаржуулахад идэвхтэй оролцох, тус сэтгүүлийг нийтийн захиалгад оруулах шаардлагатай.

- Багш нарыг судалгааны ажилд идэвхтэй оролцуулж, хийсэн судалгааны ажил, бичсэн сурах бичиг, гарын авлага, орчуулсан бүтээлийг урамшуулах механизмыг бий болгох хэрэгтэй. Бүтээлүүдийг нь хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэгч олох, бүтээлийн чөлөө олгох, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэхэд анхаарах нь чухал. Сэтгүүл зүйн залуу багш нарыг Сурган, сэтгэл судлалын дээд курст заавал сургах шаардлагатай. Энэ бол багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах нэг чухал нөхцөл болох юм.

- Сэтгүүлч бэлтгэдэг сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлж, ном, сурах бичгийн хангамж, суралцах орчныг сайжруулах, "сургалт+судалгаа+үйлдвэрлэл"-ийн хоорондох харилцан уялдаа холбоо тасралтгүй байх боломжийг хангах хэрэгтэй.

- Сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиуд хоорондоо хамтран ажиллах, мөн практикийн байгууллагуудтай (ОНМХ) байнгын харилцаа холбоотой ажиллах, сургуулиуд гадаад харилцааг хөгжүүлж, янз бүрийн төсөл хэрэгжүүлэх, багш оюутан солилцох нь нэн чухал асуудлын нэг мөн.

- Сургалт судалгааг өндөр түвшинд хослуулж, багш нар төдийгүй оюутнуудыг сэтгүүл зүйн судалгаанд татан оролцуулах талаар онцгой анхаарах. Энэ нь оюутныг судалгаа хийх арга барил эзэмшиж, танин мэдэхүйн хүрээг өргөжүүлэхэд нөлөөлөхийн хамт ОНМХ-ийн сул болон давуу талыг, дутагдал доголдлыг сайн мэдэх, бичих

чадварыг сайжруулах, онолын сэтгэлгээг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болно.

- Хэдийгээр олон сургууль байгаа нь өрсөлдөөн бий болгох, асуудалд олон ургальч үзлийн үүднээс хандах сайн талтай боловч 18 сургуульд сэтгүүлч бэлтгэж байгаа нь манай орны хувьд ахадсан тоо юм. Ер нь чанартай 5-6 сургууль сэтгүүлч бэлтгэхэд хангалттай гэж үзэж байна. Энэ бол БСШУЯ анхааралдаа авах асуудал мөнөөс мөн.

Дээрх асуудлуудыг оновчтой шийдвэрлэж чадсан нөхцөлд сэтгүүл зүйн сургалт, судалгааны ажил алхам урагшилж, сайн боловсон хүчин төрж гарах нөхцөл бүрдэнэ.

Сэтгүүл зүй янз бүрийн шинжлэх ухаан, практик үйл ажиллагааны шинжийг өөртөө агуулсан өвөрмөц нийгмийн институт учраас түүний боловсон хүчнийг бэлтгэх асуудал үлэмж нарийн түвэгтэй, багагүй хүч, хөдөлмөр, цаг хугацаа шаардах онцлогтой. Үүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд цогц асуудалд анхаарлаа төвлөрүүлж, уйгагүй эрэл хайгуул хийх, онол, практик, арга зүйн асар их мэдлэг, дадал чадвар эзэмшиж, тодорхой туршлага хуримтлуулсан байх шаардлагатай. Энд түүний өчүүхэн хэсгийг дэлхий дахины дээд боловсролд ажиглагдаж буй шинэлэг хандлага, сэтгүүлч бэлтгэж буй өнөөгийн практикт тулгуурлан өгүүлсэн болно.

Ишлэл

¹ Мамбетказиев Е. А. 2008. Университеты XXI века: реформы и инновации. Алматы, с. 118.

² Там же, с. 161.

³ Свитич Л. Г. 2003. Профессия: журналист. М., с. 108.

⁴ Зулькафиль М., Норовсүрэн Л. 2010. Сэтгүүл зүйн тэнхим - 50 жил (Түүхийн товчоо). УБ., 9-10 дахь тал.

⁵ 2006. Боловсролын тухай хууль, тогтоомжийн эмхтгэл. УБ., 12 дахь тал.

Ашигласан бүтээлтийн жагсаалт

1. 2006. Боловсролын тухай хууль, тогтоомжийн эмхэтгэл. УБ.

2. Дэмбэрэл С. 2002. Монголын боловсрол ба оюуны хөгжил. УБ.

3. Зулькафиль М., Норовсүрэн Л. 2010. Сэтгүүл зүйн тэнхим - 50 жил (Түүхийн товчоо). УБ.

4. Зулькафиль М., Чойсамба Ч. 2005. Сэтгүүл зүйн түүх. УБ.

5. Зулькафиль М., Чойсамба Ч. 2007. Америкийн сэтгүүл зүйн түүх. УБ.

6. Түмэндэмбэрэл Д. нар. 2010. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл. УБ.

7. Кастельс М. 2000. Информационная эпоха: Экономика, общество и культура. М.: ГУВШЭ.

8. Мамбетказиев Е. А. 2008. Университеты XXI века: реформы и инновации. Алматы.

9. Свитич Л. Г. 2003. Профессия: журналист. М.

Summary

This article discusses the challenges faced by higher education, particularly journalism education, in times of globalization. The article aims to present the origin, development, current situation, and challenges of modern journalism education in Mongolia by using the examples of Mongolian colleges and universities that have journalism programs. Furthermore, the author offers solutions to the major challenges.